

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/301/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn  
Аудитын менежер: О.Амаржаргал  
Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК  
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл  
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИХ	Ардын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуулмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024-02-05 № 01/95

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.ДУЛАМЖАВ ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилдасан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангаар анхан шатны баримтаар нотлогдохгүй 41,134.3 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа үнийн харьцуулалт хийгдээгүй, 30,412.5 мянган төгрөгийн халаалтын төлбөр төлж өр үүсгэсэн, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тодруулга тайлан бэлтгээгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д; 5 дугаар зүйлийн 5.1.4-д; 20 дугаар зүйлийн 20.2.3-д; 20.2.5-д; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д; 50 дугаар зүйлийн 50.1-д; 50.1.1-д; 50.1.2-т заасантай нийцээгүй, УСНББОУС1-д Эрх ба үүрэг, Толилуулга, Төхиолдсон байх, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн

019020142

эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 68,240.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>85,502,312.12</b>	<b>134,241,860.62</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	25,139,724.93	68,240,448.43
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	25,139,724.93	68,240,448.43
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	25,139,724.93	68,240,448.43
31211	Төрийн сангийн харилцах	25,139,724.93	68,240,448.43
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,362,587.19	66,001,412.19
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	94,490.00	94,490.00
35130	Эм боох материал	94,490.00	94,490.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	60,268,097.19	65,906,922.19
35410	Бичиг хэргийн материал	634,900.00	745,400.00
35420	Аж ахуйн материал	52,714,245.98	54,521,755.98
35460	Хүнсний материал	2,134,890.00	4,857,290.00
35470	Бусад хангамжийн материал	4,784,061.20	5,782,476.20
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,579,672,566.72</b>	<b>1,581,384,069.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,579,672,566.72	1,581,384,069.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,570,502,366.72	1,572,213,869.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,650,526,417.00	1,650,526,417.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-206,391,568.77	-272,537,924.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,219,238.90	197,710,399.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,434,555.64	-124,234,165.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,261,117.09	110,694,057.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-57,000,070.57	-64,224,853.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,133,665.00	71,133,665.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,117,123.29	-5,158,973.37
39217	Ном	8,305,247.00	8,305,247.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,170,200.00	9,170,200.00
39301	Програм хангамж	844,200.00	844,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,326,000.00	8,326,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>1,665,174,878.84</b>	<b>1,715,625,929.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,701,641.00</b>	<b>30,142,530.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,701,641.00	30,142,530.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,701,641.00	30,142,530.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,028,241.00	30,142,530.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,673,400.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,673,400.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,661,473,237.84</b>	<b>1,685,483,399.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,661,473,237.84	1,685,483,399.91

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	323,416,392.00	323,416,392.00
51101	Өмч: - төрийн	323,416,392.00	323,416,392.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>925,389,981.50</b>	<b>949,457,694.07</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-736,083,256.34	925,447,532.00
51220	Тайлант үеийн үр дүн	1,661,473,237.84	24,010,162.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	412,666,864.34	412,609,313.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,665,174,878.84</b>	<b>1,715,625,929.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>987,414,538.07</b>	<b>1,145,466,963.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>64,170,876.07</b>	<b>79,052,963.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>64,170,876.07</b>	<b>79,052,963.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,170,876.07	79,052,963.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,696,500.00	1,615,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	150,648.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,474,376.07	77,286,415.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>923,243,662.00</b>	<b>1,066,414,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>669,509,800.00</b>	<b>841,103,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	669,509,800.00	841,103,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,058,300.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,058,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>222,675,562.00</b>	<b>225,310,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	222,675,562.00	225,310,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>967,930,731.10</b>	<b>1,121,456,800.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>967,930,731.10</b>	<b>1,121,456,800.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>912,783,611.26</b>	<b>1,090,468,541.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>515,818,043.91</b>	<b>601,291,471.28</b>
210101	Үндсэн цалин	345,926,025.25	411,935,188.72
210102	Нэмэгдэл	144,001,411.01	160,659,769.96
210104	Урамшуулал	25,890,607.65	28,696,512.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,032,322.32</b>	<b>75,945,674.42</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,000,079.69	52,668,145.77
210202	Тэтгэмжийн даатгал	5,154,738.96	6,145,737.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,117,071.03	4,854,989.70
210204	Ажилгүйдлийн даатгал	978,221.16	1,116,072.88
210205	Эрүүл мэндийн даатгал	9,782,211.48	11,160,728.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>188,318,566.00</b>	<b>253,154,674.81</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,830,866.00	11,949,594.81

210302	Түлш, халаалт	178,938,200.00	241,140,080.00
210303	Цэвэр, бохир ус	549,500.00	65,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,642,969.00</b>	<b>17,353,553.80</b>
210401	Бичиг хэрэг	2,772,170.00	627,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,061,715.00	2,010,678.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,809,084.00	14,715,675.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,087,390.00</b>	<b>39,154,570.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	269,180.00	00.00
210502	Хоол, хүнс	32,818,210.00	39,154,570.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,883,500.00</b>	<b>4,516,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,696,500.00	1,615,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	187,000.00	2,901,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>93,000,820.03</b>	<b>99,051,697.43</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,119,000.00	7,282,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,776,820.03	91,769,197.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,147,119.84</b>	<b>30,988,259.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,086,709.00</b>	<b>30,983,570.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,578,409.00	25,107,570.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,508,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	5,876,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>60,410.84</b>	<b>4,689.19</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>19,483,806.97</b>	<b>24,010,162.07</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,219.49</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	19,219.49	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-19,219.49</b>	<b>- 00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>19,464,587.48</b>	<b>24,010,162.07</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>924,940,162.00</b>	<b>1,068,180,548.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,696,500.00</b>	<b>1,766,548.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,696,500.00	1,766,548.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,696,500.00	1,766,548.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,696,500.00	1,615,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	150,648.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>923,243,662.00</b>	<b>1,066,414,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	669,509,800.00	841,103,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	669,509,800.00	841,103,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,058,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,058,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	222,675,562.00	225,310,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	222,675,562.00	225,310,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>899,800,437.07</b>	<b>1,025,079,824.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>899,800,437.07</b>	<b>1,025,079,824.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>845,026,176.23</b>	<b>994,111,495.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	515,818,043.91	601,153,440.19
210101	Үндсэн цалин	345,710,949.28	408,256,338.95
210102	Нэмэгдэл	146,923,586.18	164,300,588.64
210104	Урамшуулал	23,183,508.45	28,596,512.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,032,322.32	76,083,705.51
210201	Тэтгэврийн даатгал	44,000,079.69	52,535,244.43
210202	Тэтгэмжийн даатгал	5,154,738.96	6,066,971.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,117,071.03	4,804,857.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,789,143.31	1,152,321.16
210205	Эрүүл мэндийн даатгал	8,971,289.33	11,524,310.91
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	187,004,400.00	224,326,310.81
210301	Гэрэл, цахилгаан	7,516,700.00	13,263,760.81
210302	Түлш, халаалт	178,938,200.00	210,997,550.00
210303	Цэвэр, бохир ус	549,500.00	85,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,485,990.00	41,896,900.00
210502	Хоол, хүнс	31,485,990.00	41,896,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	990,090.00	979,200.00
210604	Урсгал засвар	990,090.00	979,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,455,800.00	6,135,900.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,696,500.00	1,615,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,759,300.00	4,520,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,239,530.00</b>	<b>43,536,038.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,105,300.00	36,756,688.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,134,230.00	6,779,350.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,774,260.84</b>	<b>30,968,329.19</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>54,713,850.00</b>	<b>30,963,640.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,205,550.00	25,087,640.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,508,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	5,876,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>60,410.84</b>	<b>4,689.19</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>25,139,724.93</b>	<b>43,100,723.50</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>25,139,724.93</b>	<b>43,100,723.50</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>25,139,724.93</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>25,139,724.93</b>	<b>68,240,448.43</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314,999,800.00	281,813,938.61	-201,828,452.34	394,985,286.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	277,450.95	277,450.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314,999,800.00	281,813,938.61	-201,551,001.39	395,262,737.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-277,450.95	00.00	-277,450.95
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	146,627,369.64	146,627,369.64
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	323,416,392.00	412,666,864.34	925,389,981.50	1,661,473,237.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	57,550.50	57,550.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	323,416,392.00	412,666,864.34	925,447,532.00	1,661,530,788.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-57,550.50	00.00	-57,550.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,010,162.07	24,010,162.07
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	323,416,392.00	412,609,313.84	949,457,694.07	1,685,483,399.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,125,694,000.00</b>	<b>1,025,079,824.50</b>	<b>100,614,175.50</b>	91.06
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,125,694,000.00</b>	<b>1,025,079,824.50</b>	<b>100,614,175.50</b>	91.06
210	Бараа, үйлчилгээний зардал	1,087,207,700.00	994,111,495.31	93,096,204.69	91.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	652,559,700.00	601,153,440.19	51,406,259.81	92.12
210101	Үндсэн цалин	448,399,500.00	408,256,338.95	40,143,161.05	91.05
210102	Нэмэгдэл	174,311,300.00	164,300,588.64	10,010,711.36	94.26
210104	Урамшуулал	29,848,900.00	28,596,512.60	1,252,387.40	95.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,570,000.00	76,083,705.51	5,486,294.49	93.27
210201	Тэтгэврийн даатгал	55,467,600.00	52,535,244.43	2,932,355.57	94.71
210202	Тэтгэмжийн даатгал	6,525,500.00	6,066,971.89	458,528.11	92.97
210203	ҮОМШӨ ний даатгал	5,220,500.00	4,804,857.12	415,642.88	92.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,305,100.00	1,152,321.16	152,778.84	88.29
210205	Эрүүл мэндийн даатгал	13,051,300.00	11,524,310.91	1,526,989.09	88.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	256,656,600.00	224,326,310.81	32,330,289.19	87.40
210301	Гэрэл цахилгаан	14,490,200.00	13,263,760.81	1,226,439.19	91.54
210302	Түлш, халаалт	241,566,400.00	210,997,550.00	30,568,850.00	87.35
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	65,000.00	535,000.00	10.83
2105	Нормативт зардал	45,391,900.00	41,896,900.00	3,495,000.00	92.30
210502	Хоол, хүнс	45,391,900.00	41,896,900.00	3,495,000.00	92.30
2106	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	979,200.00	20,800.00	97.92
210604	Урсгал засвар	1,000,000.00	979,200.00	- 20,800.00	97.92
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,216,500.00	6,135,900.00	80,600.00	98.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,696,500.00	1,615,900.00	80,600.00	95.25
210806	Мэдээллийн технологийн зардал	4,520,000.00	4,520,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	43,813,000.00	43,536,038.80	276,961.20	99.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,033,000.00	36,756,688.80	276,311.20	99.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,780,000.00	6,779,350.00	650.00	99.99
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,486,300.00</b>	<b>30,968,329.19</b>	<b>7,517,970.81</b>	80.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,486,300.00	30,963,640.00	7,522,660.00	80.45
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	32,610,300.00	25,087,640.00	7,522,660.00	76.93
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	5,876,000.00	5,876,000.00		100.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,689.19	(4,689.19)	-

261090	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,689.19	(4,689.19)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,100,607,600.00</b>	<b>1,068,180,548.00</b>	<b>32,427,052.00</b>	97.05
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>841,103,800.00</b>	<b>841,103,800.00</b>	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	841,103,800.00	841,103,800.00	-	100.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>257,656,600.00</b>	<b>225,310,200.00</b>	<b>32,346,400.00</b>	87.45
132001	Орон нутгийн төсвөөс	257,656,600.00	225,310,200.00	32,346,400.00	87.45
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,847,200.00</b>	<b>1,766,548.00</b>	<b>80,652.00</b>	95.63
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,696,500.00	1,615,900.00	80,600.00	95.25
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,700.00	150,648.00	52.00	99.97
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,139,724.93	(25,139,724.93)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	68,240,448.43	(68,240,448.43)	-
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>36</b>	<b>37</b>		
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	-	
620003	Үйлчлэх ажилтан	15	16		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус сургууль нь анх 1977 онд 4 гэр, 2 багш, 50 сурагчтайгаар байгуулагдсан. 1980 онд ЗСБНХУ-ын хүч хөрөнгөөр 320 хүүхдийн хичээлийн байр, 70 ортой дотуур байр, 40 суудалтай гал тогооны байр ашиглалтад орсон.

Баянхангай сумын сургууль 1984 онд МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МҮЭ-ийн Төв зөвлөл, МХЗЭ-ийн Төв хорооны диплом, сурагчийн жилийн ажлыг эрхлэх төв комиссын диплом, аймгийн намын хороо, АДХГЗ, ҮЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хорооны дипломоор шагнагдаж "Аймгийн тэргүүний сургууль" цол, мандат, туг мөнгөн шагнал хүлээн авлаа. 1985 он гарсаар нийт сургуулийн дунд зарласан гэмт хэрэг, хэв журмын зөрчилгүй сургууль шалгаруулах уралдааны болзлыг биелүүлж МХЗЭ-ийн Төв хороо, БНМАУ-ын Ардын Боловсролын Яам, Прокурорын газар, НАХЯам, Дээд шүүх СГАҮЭ-ийн байнгын зөвлөлийн дипломоор шагнагдсан.

1980 оны 8 сараас эхлэн дотуур байрны багшаар Гомбодорж ажиллаж, аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөл, ардын боловсролын хэлтсээс дотуур байрны дунд зарласан уралдаанд аймагтаа 2 удаа тэргүүн байр эзлэн, 1983 онд "Аймгийн тэргүүний дотуур байр" болсон. Мөн онд Монголын эмэгтэйчүүдийн хороо, аймгийн намын хорооны соёлжилтын 1,2 шатны үзлэгээр онц дүнтэй шалгагдаж, Монголын эмэгтэйчүүдийн хорооны шагналаар шагнагдлаа.

Дотуур байрны сурагчдын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, тэдэнд урлаг, гоо сайхны үзэл бодол бий болгох зорилгоор "Атрын цуурай" хамтлаг байгуулагдаж, 5 жилийн хугацаанд 253 гаруй удаа тоглолт хийсэн байна. Аймагт тайлан тоглолтоо хийж, телевиз, радиогоор орон даяар тоглолтоо нэвтрүүлжээ. Чуулгынхан МПБ-н Төв зөвлөлийн алт, мөнгө, хүрэл медаль 12-г хүртжээ.

Баянхангай сумын сургууль 2023-2024 оны хичээлийн жилд 36 ажилтан, 250 сурагч суралцаж байна. Үүнээс бага ангид 130, ахлах ангид 44, дунд ангид 76 сурагч суралцаж байна. Эрэгтэй 125, эмэгтэй 125 байна. Малчны 77 хүүхэд суралцаж байна. 7 судлагдахуунаар Элсэлтийн ерөнхий шалгалт өгч Монгол хэл, биологи, нийгмийн ухаан, математикийн судлагдахуунаар аймаг улсын дунджид хүрсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50 хүүхдийн ортой дотуур байр 2021 онд ашиглалтад орж 2023-2024 оны хичээлийн жилд 50 сурагч амьдарч байгаагаас. Дотуур байранд эрэгтэй 30, эмэгтэй 20, бага ангийн 21 сурагч, дунд ангийн 18 сурагч, ахлах ангийн 11 сурагч байна.

Баянхангай сумын ерөнхий боловсролын сургууль нь Төв аймгийн Засаг даргын 2013 оны 10 дүгээр сарын 11-ний өдрийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн 0000925 тоот гэрчилгээтэй.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Баянхангай сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол шинжлэх ухааны ерөнхий газрын харьяа сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага юм.

Тайлант онд Боловсролын ерөнхий хууль шинэчлэгдэн батлагдаж үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан, уян хатан тогтвортой, нээлттэй, насан туршийн суралцахуйг дэмжсэн, ардчилсан хүмүүнлэг ёсыг дээдэлсэн сахисан байх, боловсролын

санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтлах тэргүүлэх салбар байна гэж зарчмаа тодорхойлсон.

Боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцахуйгаас эхэлнэ. Албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол гэсэн түвшинтэй байна. Иргэний амьдралын орчинд суралцахуйг хүлээн зөвшөөрч, үр дүнг баталгаажуулж болно, албан болон албан бус боловсролын агуулга, стандартыг тогтооно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" байна.

Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,711.5 мянган төгрөгөөр буюу 0,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	25,139.7	68,240.4	43,100.7
Бараа материал	60,362.6	66,001.4	5,638.8
Үндсэн хөрөнгө	1,579,672.6	1,581,384.1	1,711.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,665,174.9</b>	<b>1,715,625.9</b>	<b>50,451.0</b>
Өр төлбөр	3,701.6	30,142.5	26,440.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	323,416.4	323,416.4	
Хуримтлагдсан үр дүн	925,390.0	949,457.7	24,067.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	412,666.9	412,609.3	-57.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,665,174.9</b>	<b>1,715,625.9</b>	<b>50,451.0</b>

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 43,100.7 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5,638.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 84,908.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 2,346.4 мянган төгрөг нийт 87,254.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 81,615.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,711.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийг хөгжүүлэх сангаас 74,940.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр 18,540.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч хөрөнгө нэмэгдэж, 8,556.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 83,212.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөсөн байна.

Өглөгийн талаар: Тайлант хугацаанд 30,142.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны түлш, халаалтын төлбөрийг төлөөгөйтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо: Тайлант оны үр дүн 24,010.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтэд гол нөлөөлөл үзүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 916,947.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 916,947.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 28 албан тоотоор дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 48,909.9 мянган төгрөгөөр бууруулж, 868,037.4 мянган төгрөгөөр баталсан байгаа нь шалгагдагч байгууллагын хүргүүлсэн саналын үндэслэлийг харгалзан баталдаггүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 225,103.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн мэргэжлийн боловсролын-71801 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 842,951.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 799,769.6 мянган төгрөг буюу 92,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, нормативд зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 68,267.7 мянган төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Сургуулийн өмнөх боловсрол-71801	868,037.4	799,769.6	68,267.7	92,1
1.1	Байр ашиглалтын үйлчилгээ-80226	1,808.0	1,808.0		100
1.2	Сургалт семинар-80312	904.0	893.8	10.1	98,9
1.3	Эрүүл мэндийн дэмжих-81605	1897,3	1662,5	234,8	87,6
1.4	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг-81801	32610,3	25087,6	7522,6	76,9
1.5	Дотуур байрны үйлчилгээ-81806	70732,9	60282,0	10450,8	85,2
1.6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816	18663,3	18641,0	22,0	99,9
1.7	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх-81823	4068,0	4066,0	2,0	
1.8	Насан туршийн боловсрол-81827	1610,0	322,0	1288,0	20
1.9	Боловсролын стандарт, сургалт-81834	573991,0	540352,3	33638,6	94,1
1.10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835	159905,7	144887,6	15018,0	90,6
1.11	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт-81844	150,6	150,6	0	100
1.12	Сурах бичгийн түрээс	1696,5	1615,9	80,6	95,2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус байгууллага нь худалдан авах ажиллагаагаар бараа үйлчилгээ 36,756.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал 6,779.3 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 41,896.9 мянган төгрөг, нормативт зардал 41,896,9 төгрөгийн худалдан авалт хийхдээ Засаг даргын тамгын газраас нэгдсэн журмаар тендер сонгон шалгаруулалт хийдэг, нэгдсэн гэрээтэй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням, шинжээч Д.Энх-амгалан, Ө.Бат-оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 1,665,174.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 24,977.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 18,733.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой, цалингийн зардал 40,143.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой 32,330.2 мянган төгрөг, хоол хүнс 3,495.0 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардал 276.3 мянган төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 7 мэдээлэл, 10 мэдээлэл байршуулаагүй, шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24,515.0 мянган төгрөгийн зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний хөрөнгийн хэмжээ 169,323.3 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 323,416.4 мянган төгрөг, 154,093.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хөрөнгө өр төлбөр болон өмчийн хувь оролцоог зөв дүнгээр тусгасан ба үнэлгээ болон хуваарилалтын залруулга, холбогдох тодруулгыг зохих ёсоор хэмжсэн тайлбарласан байх "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

4.4.2.2 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 41,134.3 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Засварын аудитаар 6 алдаа зөрчил илрүүлэн танилцуулсан боловч, алдаа зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчил дутагдал давтагдсаар байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд илрүүлсэн 81,363.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,407.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 1,6 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	30,412.5	1	30,412.5	
Зөвлөмж	1	3,277.0		3,277.0	
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>33,689.5</b>	<b>1</b>		

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулдаг эсэх, харьцуулалт сонгон шалгаруулалт хийдэг эсэх, гэрээ хэлцэл албан бичиг хэргийн стандартын хэрэгжилт үзэх

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 33,689.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 30,412.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,277.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

**5.2 Албан шаардлага**

5.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 3,277.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант онд халаалтын төлбөр 30,412.5 мянган төгрөг төлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хөрөнгийн данстай холбоотой**

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, элэгдлийн хугацааг бодитой тодорхойлж бүртгэлд тусгаагүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулан тайлагнаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэж, тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

#### **2. Бичиг хэрэг хөтлөлтийн талаар**

Илрүүлэлт: Тус байгууллага нь бичиг хэрэг хөтлөлт, дээд газраас ирсэн бичиг, албан тоотууд, тушаал шийдвэрүүд нь баримт бичиг бүртгэл, хүлээн авах, явуулах журам, архивд шилжүүлэх ажил нь зохион байгуулалтгүй баримт бичгийг боловсруулах, ангилах, баталгаажуулах, хэрэг болгон бүрдүүлэх, ач холбогдлыг нь үнэлэн тогтоогоогүй байгаа нь албан хэрэг хөтлөлтийн стандарттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: MNS5140-2:2021 Албан хөрөнгө хөтлөлтийн стандартыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртөө нөхсөн.	1	144,456.1					1	144,456.1				
Харилцагч байгууллагад өр төлбөр үүссэн байгааг баталгаажуулаагүй	1	30,412.5			1	30,412.5						
Бараа материал худалдан авах анхан шатны баримт дутуу бүртгэгдсэн.	1	3,277.0			1	3,277.0						
Үндсэн хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, элэгдэх хугацааг бодитой тооцоогүй	1						1					
Бичиг хэрэг хөтлөлт зохион байгуулалт, эмх цэгцгүй	1						1					
Дүн	3	178,145.6			1	33,689.5	3	144,456.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил хугацаа хоцорсон 7 мэдээлэл, 10 мэдээлэл байршуулаагүй, шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил	1	24,515.0			1	24,515.0				

үйлчилгээний мэдээллийг мэдээлээгүй							
Дүн	1	24,515.0			1	24,515.0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Засгийн газрын оролцоо 154,093.1 мянган тегсгөөр зөрүүтэй байна	1	154,093.1				1	154,093.1
Цахим баримтын бүрдэлд 7,987.4 мянган тегсгэгийн баримт илүү бүртгэгдсэн	1	41,134.3			1	41,134.3	
Дүн	2	195,227.4			1	41,134.3	154,093.1
Нийт дүн	3	219,742.4			2	65,649.3	154,093.1



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 25-Н/НДС16-ТӨА-2024  
Зөмнө-Улаан-Уул

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тайлант онд халаалтын төлбөр 30,412,500 /гучин сая дөрвөн зуун арван хоёр мянга таван зуун/ төгрөг төлөөгүй байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Халаалтын төлбөр төлөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>7</sup> ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Дуламжав, нягтлан бодогч Х.Даваажамц нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

<sup>7</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040109



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 10 өдөр

Дугаар

22-115/0516-ТӨА-2024/

Зуунмод

301/КА-ЕТА-ТНЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримт 41,134,300 /дөчин нэгэн сая нэг зуун гучин дөрвөн мянга гурван зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;

<sup>1</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040100

2. Цаашид алдаа<sup>2</sup>, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Дуламжав, нягтлан бодогч Х.Даваажамц нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
/С.ОЮУНГЭРЭЛ/



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар АЗ-НХТ 0516-ТӨА-2024/

Зуунмод

30/НА-СТА-ТНБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 24,515,000 /хорин дөрвөн сая таван зуун арван таван мянган/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, хугацаа хоцорсон 7 мэдээлэл, 10 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;" 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>3</sup> ирүүлэх;

<sup>3</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040193

2. Цаашид алдаа<sup>4</sup>, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Дуламжав, нягтлан бодогч Х.Даваажамц нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
/Л.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
/С.ОЮУНГЭРЭЛ/

<sup>4</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар

24-14570516-ТӨА-2024/301

Зуунмод

ТӨА-СТА-7ШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримт 3,277,000 /гурван сая хоёр зуун далан долоон мянган/ төгрөгөөр дутуу бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх<sup>5</sup>, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

<sup>5</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040106

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>6</sup> ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Б.Дуламжав, нягтлан бодогч Х.Даваажамц нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

A handwritten signature in black ink, written over the stamp and the text of the auditor.

/С.ОЮУНГЭРЭЛ/

<sup>6</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И-мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)